

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ХЭРЭГЖИХ 2025 ОНЫ ДЭД ХӨТӨЛБӨРҮҮДЭД ТУСГАГДСАН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ**

Д/д	Үйл ажиллагаа	Хэрэгжилт	Хувь
ДУНДГОВЬ АЙМГИЙН ХЭМЖЭЭНД “ХҮНИЙ НӨӨЦИЙГ ДЭМЖИХ” ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ЗОРИЛГО. Төрийн болон аж ахуйн нэгж, байгууллагын хүний нөөцийн мэдлэг боловсрол, мэргэшлийн ур чадварыг дээшлүүлж, эцсийн үр дүнг дээдэлсэн, урамшуулал хариуцлагын тогтолцоо бүхий чадахуйн зарчимд тулгуурласан мэргэшсэн, чадварлаг төрийн албыг бүрдүүлж, аж ахуйн нэгж, байгууллагын хүний нөөцийн өрсөлдөх чадвар, удирдлагын манлайллыг дээшлүүлэхэд оршино.			
Зорилт 1. Аймаг орон нутагт шаардлагатай боловсон хүчнийг салбар бүрд тасралтгүй бэлтгэж, боловсон хүчний хангалтыг нэмэгдүүлнэ.			
1.1	Орон нутагт хэрэгцээтэй, нэн шаардлагатай боловсон хүчнийг шинээр бэлтгэх	2025 онд бүх сумдад гадаад паспортын захиалга авах эрх нээсэнтэй холбоотой хэлтсийн нэг цэгийн үйлчилгээний улсын бүртгэгч дээр сумдын улсын бүртгэгчдийг гадаад паспортын бүртгэлийг хэрхэн хөтлөх талаар программын дадлагыг хийлгэсэн. Мөн Дэлгэрцогт, Өндөршил сумдын улсын бүртгэгчид шинээр томилогдсон тул ажлын байрны дадлага өгөх программын сургалтыг Сайнцагаан сумын улсын бүртгэгч Ш. Чулуун, иргэний улсын бүртгэлийн хууль журам, анхаарах асуудлаар ахлах бүртгэгч нар заавар зөвлөмж өгч ажиллалаа. Шинээр томилогдож байгаа улсын бүртгэгчдэд хүний нөөцийн сургалтын системийг хэрхэн ашиглах, улсын бүртгэлийн хууль тогтоомж, дүрэм журам зэргийг хэрхэн судалж эзэмшиж өөрийн мэдлэг чадвараа байнга сайжруулж ажиллах талаар зөвлөгөө зөвлөмжийг өгч ажиллаж байна. Хяналтын улсын байцаагчийн Мэдэгдлийн хүрээнд улсын бүртгэгчдэд үнэт цаасны зарцуулалт, иргэний гэр бүлийн статистик тоон мэдээ гаргах, иргэний бүртгэлийн системд үнэт цаасны бүртгэлийг хэрхэн хийх талаар арга зүйн зөвлөмж өгөх сургалт хийх тухай дотоод албан бичгийг улсын бүртгэгчдэд хүргүүлэн 4 сарын 7-ны өдөр сургалтыг цахимаар зохион байгууллаа. Сургалтад 11 бүртгэгч хамрагдсан. Хэлтсийн залуучуудын хөгжлийн зөвлөлөөс санаачлан 2025 оны 1-р улиралд стандарт мөрдөх сарын аян зохион байгуулж 2025.02.10-	100%
1.2	Аймгийн хэмжээнд шаардлагатай байгаа мэргэжилтэй боловсон хүчний хэрэгцээний судалгааг жил бүр салбар, салбараар гаргах		
1.3	ЕБС төгсөгчдөд ажил, мэргэжлийн онцлогоо танилцуулж, тэднийг орон нутагт шаардлагатай байгаа мэргэжил сонгон авч суралцуулах чиглэлээр уулзалт, хэлэлцүүлэг, үзүүлэх сургалт зэрэг үйл ажиллагааг байгууллага бүр зохион байгуулах		

		2025.02.17 хугацаанд “Бурмаар тэтгэхээр Урмаар тэтгэ” долоо хоног болгон зарлаж хэлтсийн албан хаагчид цахимаар болон захидлаар бие биедээ сэтгэгдэл мэдрэмжээ хуваалцан долоо хоногийн эцэст дүгнэн нэгдсэн сургалт зохион байгуулсан. Мөн дээрх аяны хүрээнд албан хаагчид дотнын хүндээ чин сэтгэлийн мэндчилгээ дэвшүүлж хүргүүлсэн. Стандарт мөрдөх сарын аяны хүрээнд “Санхүүгийн сахилга бат”-ын долоо хоног зарлан хэлтсийн даргын зүгээс сургалт зохион байгуулж нийт албан хаагчид хуримтлалтай болж өдөр бүр сонирхолтой даалгавар гүйцэтгэн хамгийн хамгийн шалгаруулсан. Ажлын байрны соёл, стандартыг сайжруулах 5S зарчмыг албан хаагчдад мэдээлэл хүргэн танилцуулж, өрөө, тасалгаа, нэг цэгийн үйлчилгээний танхимд их цэвэрлэгээ зохион байгуулан ажиллаа. Цэгц билиг сургуулийн 10А, 10Б ангийн сурагчдад “Бид иргэдээ сонсож шийднэ өглөөлөг” арга хэмжээг зохион байгуулж хэлтсийн үйл ажиллагааг танилцууллаа. Албан хаагчдад “10 минутын дадал” дасгал хөдөлгөөнийг өдөр бүр зохион байгуулж байна. “СТАНДАРТ МӨРДӨХ АЯН” зохион байгуулан стандартыг хэрэгжүүлж ажиллаж байна.	
Зорилт 2. Төрийн алба хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулж, Нийгмийн асуудлыг шийдвэрлэх замаар тогтвортой байдлыг хангана.			
2.1	Шаардлагатай төрийн албан хаагчдад орон байр болон эрүүл мэндийн дэмжлэг үзүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх	ИУБГазраас ирүүлж байгаа чиглэл, зөвлөмж, мөрдөгчийн тэмдэглэлийн хүрээнд Хяналтын улсын байцаагч, иргэний улсын бүртгэлийн ахлах бүртгэгчийн зүгээс улсын бүртгэгчдэд тухай бүр цахимаар сургалтыг зохион байгуулж ирсэн бөгөөд тайлант хугацаанд 3 удаа сургалтыг цахимаар зохион байгуулсан. Гадаад паспортын бүртгэлийн талаар, шинээр томилогдсон улсын бүртгэгчдэд ажлын байрны дадлагажуулах сургалтыг хуваарь гарган хэлтсийн нэг цэгийн	100%
2.2	Шинээр томилогдсон төрийн албан хаагчдыг Удирдлагын академийн төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх сургалтад хамрагдахад дэмжлэг үзүүлэх		
2.3	Шинээр томилогдсон албан хаагчдыг "Сургаж дадлагажуулахад" дэмжлэг үзүүлэх		
2.4	Төрийн албан хаагчдын ёс зүй, удирдлагын манлайллыг сайжруулах сургалт, зөвлөгөөн зохион байгуулж, мэдлэгээ тэлэх боломж бүрдүүлэх		

2.5	ISO9001 Чанарын удирдлагын тогтолцоо стандартыг байгууллагуудад хэрэгжүүлэх, нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх	үйлчилгээний танхим болон Сайнцагаан сумын ажлын байранд 4 удаа зохион байгуулж ажилласан. Сургалтад 12 улсын бүртгэгч хамрагдсан. УБЕГазрын 2025 оны 06 сарын 25 -ны өдрийн 1/8305 тоот зөвлөмжийн хүрээнд иргэний улсын бүртгэлийн тасгаас улсын бүртгэгчдэд чиглэл өгөх сургалтыг цахимаар зохион байгууллаа. Сургалтаар гэрлэлт дуусгавар болсны бүртгэл хөтлөхөд анхаарах асуудлаар улсын ахлах бүртгэгч Б. Сайхантуяа, "Шүүхийн шийдвэрийн хуулийн хүчин төгөлдөр хугацааг анхаарах асуудлаар хяналтын улсын байцаагч Д. Нямсүрэн нар мэдээлэл өглөө. Гэр бүлийн тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, Иргэний улсын бүртгэл хөтлөх журам зэрэг холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллахаас гадна иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сан, архивын санд бүртгэл хийхээс өмнө заавал шалгаж нягтлах, өргөдлийн шаардлагыг хангуулж дэлгэрэнгүй бичүүлж байх, шүүхийн шийдвэрийн хүчин төгөлдөр хугацаа гэдгийг хэрхэн ойлгох, итгэмжлэл болон шүүхийн шийдвэрийн нэхэмжлэлийн шаардлага, тогтоох хэсгийн утга, агуулгыг бүрэн гүйцэт уншиж танилцан үнэн зөв бүртгэл хөтлөхөд анхаарч ажиллах талаар үүрэг даалгавар, мэдээлэл арга зүйн зөвлөмж өглөө. Сургалтад нийт 12 албан хаагч хамрагдлаа. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газраас ирүүлсэн 2025 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн 4/5158 дугаартай чиглэлийн дагуу 2025 оны 4 дүгээр сарын 24-ны өдөр байгууллагын шуурхай хурал дээр чиглэлийг танилцуулсан ба 4 дүгээр сарын 25-ны сумдын 12 бүртгэгчид мэдээллийг цахимаар хүргэлээ. 2025оны 11сарын 5-ны өдөр УБЕГазрын Эд хөрөнгийн бүртгэлийн газраас зохион байгуулсан Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөхөд анхаарах асуудал нотириатын зуучлалаар эрхийн улсын бүртгэл хөтлөх
2.6	Төрийн албан хаагчдыг байр орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамрагдах, орон сууц барих газрын асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх	
2.7	Шаардлагатай сумдын хүний нөөцийн сургалт, нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх	
2.8	Эрүүл мэндийн тусламж, дэмжлэг нэн шаардлагатай төрийн албан хаагчдад эрүүл мэндийн дэмжлэг үзүүлэх	
2.9	Орон нутагт шилжин ирж ажиллаж байгаа албан хаагчийн гэр бүлийг ажлын байраар хангахад дэмжлэг үзүүлэх	
2.10	Төрийн албан хаагчдын ажлын гүйцэтгэлд үндэслэн урамшуулах	

		мэдлэг олгох тухай цахим сургалтанд нийт 17 бүртгэгч хамрагдлаа. Хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 2 удаа цахимаар, хуулийн этгээд, эд хөрөнгийн бүртгэл хөтөлж байгаа 4 бүртгэгчид ажлын байрны сургалтийг 2-3 удаа зохион байгуулсан. -Ахлах бүртгэгч Л.Мөнхсарнай 2 удаа хамрагдсан. - Аймгийн Засаг даргын санаачилгаар төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулах, төрийн албан хаагч, иргэдэд тулгамдсан асуудлыг сонсох, шийдвэрлэх, тодорхой шийдэлд хүрэх зорилгоор “Асуудал шийдэл” уулзалтыг 14 сумдад зохион байгуулсан бөгөөд уулзалтын үеэр хөдөө сумын иргэдэд бүртгэлийн үйлчилгээг сурталчилан сургалт зохион байгуулж, 4G төхөөрөмж ашиглан бүртгэлийн үйлчилгээг газар дээр нь хүргэж ажилласан. -Төрийн албаны хууль тогтоомжийн хэрэгжилтийг чанаржуулах, мэдээллээр хангах, бүтээлч үр ашигтай санал санаачлагыг дэмжих, үр дүн туршлага нэмэгдлүүлэх зорилгоор 2024 оны үйл ажиллагааны үр дүнгээрээ улсдаа болон аймагтаа тэргүүлсэн байгууллагын сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх мэдээлэл солилцож, харицан суралцах, төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах зорилгоор “Харилцан суралцах-сайн туршлага” сургалтыг зохион байгуулж Хяналтын улсын байцаагч Д.Нямсүрэн, ХЭЭХЭУБ-ийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Л.Мөнхсарнай нар хамрагдлаа. -Япон улсын ЖАЙКА олон улсын байгууллага болон Удирдлагын академи хамтран зохион байгуулсан төрийн албан хаагчдын дижитал ур чадварыг нэмэгдүүлэх сургалт Дундговь аймагт зохион байгуулж, хэлтсийн	
--	--	--	--

		мэдээлэл технологийн ажилтан Г.Алтан-Од хамрагдаж сертификат авлаа. - Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газрын харьяа сум, байгууллагын архив, бичиг хэрэг хариуцсан 100 гаруй албан хаагчдад зориулан архив албан хэрэг хөтлөлтийн шинэчлэгдсэн журмын дагуу сургалт зохион байгуулж бичиг хэргийн эрхлэгч Б.Жанчивдорж хамрагдлаа. Сургалтыг Архивын хэлтсийн дарга Т.Уранбайгаль удирдан явуулж, архив, албан хэрэг хөтлөлтийн эрх зүйн акт, шинэчилсэн журам, практик хэрэглээний талаарх мэдээллийг албан хаагчдад хүргэв. Дундговь аймгийн Засаг даргын тамгын газар, Орон нутгийн өмчийн алба, ТӨБЗГ-аас зохион байгуулсан өмчийн программын сургалтад нягтлан бодогч, нярав нар 2025 оны 10 сарын 15-16 нд сургалтад хамрагдсан.	
ДУНДГОВЬ АЙМГИЙН ХЭМЖЭЭНД “ОЮУНЛАГ ДУНДГОВЬ” ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ЗОРИЛГО. Иргэдийн насан туршдаа суралцахуйн чиглэл, багш, ажилтны орон нутагтаа тогтвортой, үр бүтээлтэй ажиллахыг дэмжин мэргэжлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлж, бүх түвшний боловсролын чанарт ахиц гаргаж, хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулж өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд оршино.			
Зорилт 1. Иргэдийн насан туршдаа суралцахуйн чиглэлээр мэдлэг эзэмшүүлж, тэдний оролцоо, хамтын ажиллагаанд суурилан хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулна.			
1.1	Иргэд, төрийн албан хаагчдийн монгол бичгийн мэдлэг, чадварыг дээшлүүлж, хэрэглээг нэмэгдүүлэх	Монгол бичгийн үндэсний хөтөлбөрийн төлөвлөгөөгөөр	
ДУНДГОВЬ АЙМГИЙН ХЭМЖЭЭНД “ЦАХИМ ДУНДГОВЬ” ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ЗОРИЛГО. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад үзүүлэх төрийн үйлчилгээг хялбаршуулах, төрийн дотоод үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх, төр, иргэн, аж ахуйн нэгж хоорондын мэдээллийн урсгалыг сайжруулах, цахим технологид түшиглэн иргэдийн амьдралын хэв маягийг хялбаршуулах, цаг хугацааг хэмнэх, зардлыг бууруулах, бүтээмжийг нэмэгдүүлэх, хүний хөгжлийг дэмжих "Цахим Дундговь"-ийг бий болгоход хөтөлбөрийн зорилго оршино.			
Зорилт 1. "Цахим засаглал"-г бэхжүүлнэ. Төрийн дотоод үйл ажиллагааг цахимжуулж уялдаа холбоо, хоорондын мэдээллийн урсгалыг сайжруулах, кибер аюулгүй байдлыг хангасан, олон улсын iso270001 стандартад тулгуурласан цахим засаглалыг бэхжүүлнэ.			

1.1	Төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системийн хэрэглээг нэмэгдүүлэх, ажлын уялдаа холбоо, бүтээмжийг сайжруулах.	1.1 12025 оны 11 дүгээр сарын 11-ны байдлаар нийт 749 албан бичиг ирснээс хугацаа хоцроосон албан бичиг байхгүй байна. 537 албан бичиг явуулсан бөгөөд хариутай 209 бичиг байна. Бичгийн барагдуулалт 100% шийдвэрлэлтийн дундаж 3 хоног байна. 1.2 2025 оны байдлаар 3900 иргэнд тоон гарын үсэг олголоо. Тоон гарын үсгийг 588 иргэнд иргэний үнэмлэхийн чипэнд, 3312 иргэний гар утсанд gsign аппликейшн суулган олгосон байна. Нийт 26826 иргэнд тоон гарын үсэг олгож 83,7 хувьтай байна. УБЕГазрын ИУБГазраас ирсэн 3/10321 тоот чиглэлийн дагуу тоон гарын үсгийг олгохдоо иргэний үнэмлэх, гарын хурууны хээг төхөөрөмжөөр уншуулан тоон гарын үсгийг олгож байна. Эрүүл мэндийн шалтгааны улмаас хурууны хээ уншигдахгүй байгаа 95 иргэнд тоон гарын үсгийг регистрийн дугаараар олгосон. Тоон гарын үсгийн мэдээг сар бүр аймгийн ЗДТГазрын хууль эрх зүйн хэлтэст 10 удаа хүргүүлсэн байна. 1.3 www.dundgovi.burtgel.gov болон https://www.gov.mn/mn/organization/dungovi-burtgel сайтуудад хэлтсийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах мэдээллийг тухай бүр оруулан шинэчлэн ажиллаж байна. 1.4 Тус хэлтсийн мэдээлэл технологийн ажилтан УБЕГ-ын МТГ-аас мэдээллийн технологийн албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалтанд хамрагдан, ярилцлага хэлэлцүүлэг хийлээ. АЗДТГ-аас зохион байгуулсан нийтийн мэдээллийн ил тод хариуцсан албан хаагчдад www.gov.mn хэрхэн сайтаа ашиглах, хөгжүүлэх сургалтанд хамрагдсан. Залуучуудын бүсчилсэн хөгжлийн хэлэлцүүлэг болж өөрийн санал бодлоо бусадтай хуваалцан туршлага судаллаа."DATA ANALYSIS" АЗДТГ-ын сургалтанд хамрагдаж сертификат авч амжилттай хамрагдлаа.	100%
1.2	Аймгийн хэмжээнд аж ахуй нэгж, байгууллага болон иргэдэд тоон гарын үсэг олгох ажлыг эрчимжүүлэх, ашиглалтыг нэмэгдүүлэх.		
1.3	Төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, иргэн, аж ахуйн нэгж байгууллага төрийн байгууллагын мэдээллийг нэг дороос авах нөхцөлийг бүрдүүлэх.		
1.4	Төрийн албан хаагчдын мэдээллийн технологийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалтыг үе шаттай зохион байгуулах.		
1.5	Төрийн байгууллагуудын кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг мэргэжлийн байгууллагатай хамтран хийж гүйцэтгэх.		

		1.5 2025 онд Тагнуулын ерөнхий газрын Дундговь аймаг дахь салбараас кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг хийж зөвлөмж ирүүлэн хамтран ажиллалаа. Цагдаагийн газрын урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч Д.Цэвэлмаа хэлтсийн албан хаагчдад “Цахим залилан” сэдвээр сургалт зохион байгууллаа.	
Зорилт 2 "Ухаалаг төрийн үйлчилгээ"-г нэвтрүүлнэ. Санал, хүсэлт, гомдлыг цахимаар авах системийг хөгжүүлж, иргэн, аж ахуйн нэгжийн цаг хугацааг хэмнэж, бүтээмж нэмэгдэнэ.			
2.1	E-mongolia.mn төрийн нэгдсэн цахим системээс аймгийн иргэдэд үзүүлж байгаа төрийн үйлчилгээг нэмэгдүүлэх.	2.1 e-mongolia.mn төрийн нэгдсэн цахим системээс 76 үйлчилгээ, 22 төрлийн лавлагаа гарах боломжтой болов. Хуулийн этгээд шинээр бүртгэх, оноосон нэр авах 2 үйлчилгээг e-business.mn сайтаар авах боломжтой.	100%
2.2	Төрийн цахим үйлчилгээний “Ухаалаг төв”-ийг байгуулан иргэн, аж ахуйн нэгжид үзүүлэх төрийн үйлчилгээг цахимаар авах боломжийг нэмэгдүүлж, орон нутгийн хэмжээнд өөртөө үйлчлэх ухаалаг шийдлийг нэвтрүүлэх.	2.2 Цахим 24/7 үйлчилгээний төвийг 4 газар байгуулсан. Хэлтсийн хэмжээнд нийт 4 Дөт /киоск/ машинаас 2025 оны байдлаар 2714 лавлагаа үйлчилгээг цахимаар авах боломжийг бүрдүүлж ажилласан. Өлзийт сумын ЗДТГ-ын хөрөнгө оруулалтаар тус сум нь Дөт /киоск/ машин шинээр авч 24/7 цахим үйлчилгээг нэвтрүүлээ.	
2.3	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид иргэд сэтгэл ханамжийн үнэлгээ өгөх, өргөдөл, гомдол, санал хүсэлтийг цахимаар хүлээн авах, хянах, шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлэх.		
ДУНДГОВЬ АЙМГИЙН ХЭМЖЭЭНД “АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ДЭМЖИХ” ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ЗОРИЛГО. Аялал жуулчлалыг тогтвортой хөгжүүлэх замаар эдийн засгийг төрөлжүүлж, бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлэн, гадаад, дотоодын жуулчдын аялах таатай орчныг бүрдүүлж, нутгийн иргэдийн орлогыг нэмэгдүүлэхэд оршино.			
Зорилт 1. Аймгийн онцлогт тулгуурласан аялал жуулчлалын өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн, дэд бүтцийг хөгжүүлж гадаад, дотоод жуулчдын тоог нэмэгдүүлнэ.			
1.1	Үйлчилгээний байгууллагуудын байршил, танилцуулга мэдээлэл, цахим хаягжилт, 360° зургийг бүртгүүлэх	1.1 Байгууллагын байршил, танилцуулга, мэдээлэл, цахим хаягжилт, 360° зургийг бүртгүүлсэн.	100%
1.2	Төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран аялал жуулчлалын ажлын байр, хөдөлмөр эрхлэлт, худалдаа, үйлчилгээний байгууллагуудын үйлчилгээний соёл, хүртээмжийг сайжруулах (жуулчны бааз, зочид буудал, гэр буудал, зоогийн газар, орон нутгийн хөтөч, тайлбарлагч,	1.2 Говь-угтаал сумын нутаг дэвсгэрт “Шанжин-Орд” ХХК-ны уул уурхайн үйлдвэрлэл, үйл ажиллагаа явуулж байгаа объектуудад үзлэг тодруулалт хийн, мэргэжил арга зүй зөвөлгөө өгч, 10 үл хөдлөх хөрөнгийг бүртгэн гэрчилгээ олголоо.	

	тогооч, жолооч гэх мэт) сургалт, нээлттэй өдөрлөг, аян зохион байгуулах	-Өлзийт сумын нутаг дэвсгэрт “Говь-Каравенсерай Лодж” ХХК-ын аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулж байгаа объектуудад үзлэг тодруулалт хийн, мэргэжил арга зүй зөвөлгөө өгч, 19 үл хөдлөх хөрөнгийг бүртгэн гэрчилгээ олголоо.	
ДУНДГОВЬ АЙМГИЙН ХЭМЖЭЭНД “НЭЭЛТТОЙ ДУНДГОВЬ” ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ЗОРИЛГО. Иргэдийн ажиллаж амьдрах, аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаа явуулах таатай орчныг нөхцөлийг бүрдүүлж, нийслэлд оршин суугаа иргэдийг татан суурьшуулж, аймгийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх замаар хүн амыг нэмэгдүүлэхэд оршино.			
Зорилт 1. Аймгийн онцлог, өв соёл, эдийн засгийн боломж, нутгийн брэнд бүтээгдэхүүн үйлчилгээг гадаад, дотоодод сурталчилна.			
1.1	Аймгийн хэмжээнд дутагдалтай байгаа хүний нөөцийг бүрдүүлэх зорилгоор орон нутгийн болон бусад иргэдийг мэдээллээр хангаж, шилжин ирэх ажлыг үе шаттай зохион байгуулах	Тайлант хугацаанд 1905 иргэн шилжин ирсний бүртгэлд хамрагдсанаас гадны аймаг хотоос 678 иргэн бүртгэгдсэн. Гадны аймаг хотоос шилжин ирсэн 16-аас дээш насны 366 иргэн, 16-аас доош насны 314 иргэн, аймаг доторх шилжилт хөдөлгөөн сумаас сум, багаас багт 16-аас дээш насны 594 иргэн, 16-аас доош насны 633 иргэн шилжилт хөдөлгөөний бүртгэл хийлгэсэн байна. Улаанбаатар хотоос 335 иргэн, Өмнөговь аймгаас 120 иргэн шилжин ирсэн нь гадны аймаг хотоос шилжин ирсэн иргэдийн 67,1 хувийг эзэлж байна. Тайлант хугацаанд 1504 иргэн өөр аймаг хотод шилжин явснаас 16- аас дээш насны 888, 16-аас доош насны 616 иргэн өөр аймаг хотод шилжин явсан хөдөлгөөний бүртгэлд хамрагдсан бөгөөд хамгийн их буюу Улаанбаатар хотод 16- аас дээш насны 544, 16-аас доош насны 337 нийт 881 иргэн, Өмнөговь аймагт 295, иргэн шилжсэн нь 78,1 хувь байна.	100%
1.2	Шилжин суурьшиж буй иргэн, аж ахуйн нэгжийн сайн жишээгээр контент бэлтгэн орон нутагт байгаа таатай боломж, давуу талыг сурталчлах		
1.3	Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй орон нутаг руу чиглэх шилжилт хөдөлгөөний бодлого, дэмжлэг, урамшууллын талаар иргэдэд шуурхай мэдээллээр ханган ажиллах		

---oOo---